МУИС | НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

2026 оны дотоод аудит • ISO 9001:2015 / ISO 21001:2018 • ЗТС 5 газар (түүврээр), 7 бүрэлдэхүүн сургууль

ТОХИРОЛ: 341 ҮЛ ТОХИРОЛ: 0 АНХААРАХ: 33 САЙЖРУУЛАХ: 28 ДАВУУ ТАЛ: 5

1 Нэгжүүдийн гол ажиглалт ба авах арга хэмжээ /аудитын ажиглалт/

Чиглэл	Т / УТ / А / С / Д	Гол ажиглалт	Сайжруулах арга хэмжээ
ЗТС (5 газар)	145 / 0 / 9 / 1 / 4	**ХҮГ-т** гадаад, дотоод орчны нөхцөл байдлыг нэгтгэн шинжлэх шаардлагатай. Удирдлагын дэмжлэгийг эерэгээр үнэлсэн байна. **СХЧБГ-т** үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хариу арга хэмжээг баримтжуулахад анхаарах шаардлагатай. СиСи системийн мэдээллийн үйлчилгээг сайн туршлагаар тэмдэглэсэн. **ЗХНГ-т** нэгжийн эрсдэлийн шинжилгээ, ажилтны хөгжил, сургалтын нөөц болон цахимжуулалтын асуудал хөндөгдсөн. **СХГ-т** нэгжийн орчны болон эрсдэлийн шинжилгээ дутуу байгааг анхааруулсан; үйл ажиллагааны цахим бүртгэл, хяналтыг давуу тал гэж үнэлсэн. **ОХГ-т** орчны шинжилгээндээ шинэчлэл хийхэд анхаарах шаардлагатай. Оюутны хөгжлийн хөтөлбөрийг батлуулж, СиСи системд шинэ цэс хөгжүүлсэн нь сайн туршлага болсон.	Нэгж бүр орчин, эрсдэлийн үнэлгээг шинэчилж, хариуцагч, хугацаа, арга хэмжээтэй холбох; сайн туршлага түгээх.
ШУС	36 / 0 / 0* / 0* / 0*	Сургалтын орчны аюулгүй байдалтай холбоотой галын үед нүүлгэн шилжүүлэх зураглал, гарц, тэмдэглэгээний бэлэн байдлыг нягтлах; тусгай хэрэгцээтэй суралцагчдын ариун цэврийн өрөөний хүртээмж, ашиглах боломжийг үнэлэх; сургалтын хөтөлбөрийн хороодын хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг бүртгэж, тайлагнах зохицуулалтыг сайжруулахад анхаарах шаардлагатай.	Орчны нөхцөлийг холбогдох газартай хамтран үнэлж, шийдвэрийн биелэлтийг бүртгэл, нотолгоогоор хянах.
МТЭС	36 / 0 / 0* / 0* / 0*	Галын аюулгүй байдал, хичээлийн байрны нүүлгэн шилжүүлэх зураглал, аврах гарц, чиглүүлэх тэмдэглэгээний бүрэн байдал болон бэлэн байдлыг нягтлах, хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээтэй суралцагчдад зориулсан ариун цэврийн өрөөний хүртээмж, ашиглах боломжийг үнэлэх шаардлагатай.	Аюулгүй байдал, хүртээмжийн засварыг эрэмбэлэх; хорооны шийдвэр бүрийн хариуцагч, хугацааг тогтоох.
БС	34 / 0 / 2 / 2 / 0	Багшийн хүрэлцээ, ажлын ачааллын зохистой байдал, IV байрны насжилттай холбоотой сургалтын орчны эрсдэл, стратегийн зорилтын KPI-ийн гүйцэтгэлийн шинжилгээ, сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр ажил хийсэн эсэхээс гадна түүний үр нөлөөг үнэлэх асуудал чухал байна.	Хүний нөөц, орчны эрсдэлийг нөөцийн төлөвлөгөөнд тусгах; KPI ба сайжруулалтын үр нөлөөг шинжлэх.
УТСОУ ХНУС	23 / 0 / 6 / 9 / 0	Танхимын агааржуулалт, ширээ сандлын элэгдэл, хичээл үзэх болон сонсох нөхцөл зэрэг сургалтын орчны асуудал; харааны бэрхшээлтэй суралцагчдад үзүүлэх дэмжлэг, тохируулгын хэрэгцээ; сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний хяналт; удирдлагын шийдвэр, мэдээллийг ажилтнуудад хүргэх шаардлагатай.	Орчны хэрэгцээг эрэмбэлэх; санал хүсэлт, удирдлагын шийдвэрийн хэрэгжилтийг нотолгоотой хянах.
ИТС	26 / 0 / 0 / 6 / 0	Сайжруулах зургаан чиглэл: (1) шинээр баталсан техникчийн орон тооны ажлын байрны тодорхойлолт, (2) тэнхимүүдийн жилийн төлөвлөгөөний нэгдсэн загвар ба баталгаажуулалт, (3) ажилтны хөгжлийн санхүүжилтийн хуваарилалтын баримтжуулалт, (4) гадаад албан бичгийн хаяг, орчуулга, бүрдэл, (5) 2026 оны гэрээний бүртгэл, (6) хөтөлбөрийн хорооны хэлэлцсэн асуудлын шийдвэрлэлтийн тайлагнал шаардлагатай.	Холбогдох АБТ-ыг баталгаажуулах; тэнхимийн жилийн төлөвлөгөөг нэг загварт оруулж захирлаар батлуулах; сургалт, хөгжлийн санхүүжилтийн шийдвэр, хуваарилалтыг баримтжуулах;

ХЗС	17 / 0 / 8 / 8 / 0	Баримт бичгийн баталгаажуулалт, огноо, бүрдэл, хувилбарын хяналт; гадаад, дотоод орчны болон сонирхогч талуудын шинжилгээ; эрсдэлийг тодорхойлох, арга хэмжээ төлөвлөх; судалгаа, зорилтын гүйцэтгэлийн үр дүнг шийдвэр гаргалтад ашиглах шаардлагатай.	Баримт бичгийн хяналтыг нэг мөр болгож, эрсдэл ба KPI-г шийдвэр, хэрэгжилтийн нотолгоотой холбох.
ШУТУБП	24 / 0 / 8 / 2 / 1	менежментийн тогтолцооны хамрах хүрээний баталгаажуулалт, төвүүдийн процессын зураглалын нэгдмэл формат, KPI-ийн хэмжих аргачлал, эрсдэлийн арга хэмжээний төлөвлөгөө, өөрчлөлт болон нөөцийн төлөвлөлтийг цэгцлэх шаардлагатай.	Хамрах хүрээ, процессын загварыг баталгаажуулах; KPI-ийн аргачлал, хариуцагч, нөөцийн төлөвлөгөөг тогтоох.

*Тайлбар: Т–тохирол; УТ–үл тохирол; А–анхаарах; С–сайжруулах боломж; Д–давуу тал. *ШУС, МТЭС-ийн тоон ангилал 0 боловч тайлбар хэсэгт ажиглалт бий гэж тайлагнасан байна. Нэгжүүдийн хамрах хүрээ, шалгуур ялгаатай тул тоогоор нь эрэмбэлэхгүй.*

2. Удирдлагын түвшинд хэлэлцэх асуудал, шийдвэрийн санал

Тэргүүлэх асуудал	Хурлаас хэлэлцэж шийдвэрлэх санал	Хэрэгжилтийг нотлох баримт
Эрсдэл ба боломж	Нэгжүүдийн орчин, эрсдэлийн үнэлгээ, хариу арга хэмжээг нэгдсэн аргачлалтай болгох.	Эрсдэлийн бүртгэл; арга хэмжээ, хариуцагч, хугацаа; үр нөлөөний хяналт
Баримтжуулалт, KPI	Процессын эзэн, баримтын баталгаажуулалт, KPI-ийн тодорхойлолт, мэдээллийн эх сурвалжийг нэг мөр болгох.	Батлагдсан журам, процессын зураглал; KPI паспорт, тайлан
Аюулгүй байдал, хүртээмж	Сургалтын орчны асуудлыг эрсдэлээр эрэмбэлж, засвар болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах.	Орчны үнэлгээ; эрэмбэлсэн хэрэгцээ; төсөв, хэрэгжилтийн бүртгэл
Санал хүсэлт, шийдвэр	Судалгаа, хөтөлбөрийн хороо, удирдлагын шийдвэрийн мөрөөр авсан арга хэмжээг үр дүнтэй нь хянах.	Шийдвэрийн бүртгэл; хэрэгжилт, үр нөлөөний нотолгоо
Хэрэгжилтийн хяналт	Нэгж бүрийн сайжруулалтын төлөвлөгөөнд хариуцагч, хугацаа, шалгуур тогтоож дараагийн хурлаар тайлагнах.	Нэгдсэн хэрэгжилтийн хүснэгт; дараах хяналтын тайлан

3. Нэмэлт шаардлагатай мэдээлэл

Өмнөх аудит	Судалгаа, санал хүсэлт	Тогтолцооны төлөвшил
2025 оны хөндлөнгийн аудит: 0 үл тохирол, 5 сайжруулах боломж, 6 анхаарах, 4 давуу тал; нэгдмэл байдлын үнэлгээ 82%. Энэ үзүүлэлтийг 2026 оны өөр аргачлалын тоотой шууд харьцуулахгүй.	2026 оны багш, ажилтны сэтгэл ханамжийн болон байгуулагын соёлын судалгаа авсан. Судалгаанд 166 багш, 42 ажилтан, байгууллагын соёлын судалгаанд 98 багш ажилтан оролцсон. Дүгнэлт хараахан тооцоогүй байна.	НМТ-ны гарын авлага, журмууд, процессын зураглалууд, хөтөлбөрийн үнэлгээ зэрэг ажил хийгдэж байна.

4. Нэгдсэн дүгнэлт

Аудитын хамрагдсан түүвэрт үл тохирол бүртгэгдээгүй ч эрсдэлийн шинжилгээ, баримтжуулалт, гүйцэтгэлийн хэмжилт, сургалтын орчны хүртээмж, шийдвэрийн хэрэгжилтийн хяналт хэд хэдэн нэгжид давтагдсан. Хурлын гол үр дүн нь эдгээр асуудлыг хариуцагч, хугацаа, нөөц, нотолгоотой шийдвэр болгон баталгаажуулах явдал юм.